



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН АЛБА ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Тайланг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

Засаг даргаЦ.Баттөр

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

.....

Төлөвлөгөөг тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ-ын

ЗахиралЖ.Мөнхзориг

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

.....

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН АЛБА ОНӨААТҮГ-ЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
3.1.1	Дүүргийн засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2055 оны “Бүтээн байгуулалтын жил” төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах	-	Хамрагдах айл өрхийн тоо	-	-	Өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж 4 бүлэг 12 зорилт 26 арга хэмжээг төлөвлөн цаг хугацаанд тайлагнаж ажиллаад байна. 1.Дүүргийн засаг даргын 2024 оны А/462 дугаар захирамжийн дагуу хөрсний болон булгийн ус гадагшилж хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байршлуудад шаардлагатай арга хэмжээ авах ажлын хүрээнд 2025 оны 1, 2, 3 дугаар саруудад 2 хороонд 1 ховоо машин дайрга асгаж түрж тэгшилсэн, 7 хороонд 1 ховоо машин дайрга асгаж 3,000 метр газарт суваг татаж, далан босгосон, 9 дүгээр хороонд 50 метр газар суваг татаж усны урсцыг нэмэгдүүлсэн, 24 дүгээр хороонд 14 ховоо машин дайрга асгаж, 908 мерт газарт суваг татаж, усны урсцыг нэмэгдүүлсэн, 26 дугаар хороонд 35 ховоо машин дайрга асгаж, 10,870 метр газарт суваг, далан сэргээн татаж, Төгөлдөрийн гүүрний доод талын мөсийг хагалж,	100%

					усны урсцыг нээсэн, 33 дугаар хороонд тахилт 27 дугаар гудамжинд хоолой битүүрснийг авч, хавтан тавьсан, 35 дугаар хороонд 18 ховоо машин дайрга асгаж, 1170 метр газарт суваг татаж, далан босгосон, 40 дүгээр хороонд 1 ховоо машин дайрга асгаж, 740 метр газарт суваг татаж, сувагчилж голдирол сэргээсэн, 41 дүгээр хороонд 4 ховоо машин дайрга асгаж, 160 метр газарт суваг татаж, голын голдирол сэргээж ажилласан. 2. Дүүргийн засаг даргын 2025 оны А/150 дугаар захирамжийн дагуу 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 2, 12, 15, 18, 19, 20, 22, 24, 26, 28, 29, 38 дугаар хороодод 84 ширхэг самбар буулгасан, 10 ширхэг самбар буулгах боломжгүй, 15 ширхэг самбар айлын газар (кадастрт) орсон, нийт 84 ширхэг самбар буулгаж ачиж тээвэрлэсэн. 3. Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2025 оны А/35 дугаар захирамжийн дагуу орц, гарц чөлөөлөх ажлын хүрээнд 18 дугаар хороонд 16 байрны баруун хойно байрлах 20 авто гараашийг буулгаж, хог шороог цэвэрлэн ачиж тээвэрлэсэн, 19 дүгээр хороонд 2 гараашийг буулгаж нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөн ажилласан.	
--	--	--	--	--	--	--

					4. Дүүргийн засаг даргын 2025 оны А/48 дугаар захирамжийн дагуу 14,16,18,19, 23, 29, 31 дүгээр хороодод 1 байшин, 1 орон сууцны өргөтгөл, 1 хуушуурын гэр, 7 граж, 7 аж ахуй нэгжийн хашааг буулгасан мөн 1 үерийн далан цэвэрлэсэн. Нийт 69 ховоо машин хог ачиж тээвэрлэн хогийн цэгт төвлөрүүлэн хаясан. 5. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн Засаг даргын 2025 оны А/338 дугаар захирамжийн №2025-03/307 тоот гэрээний дагуу 26 дугаар хороо улаан чулуутын энгэрт ойн зурвас байгуулах талбайд модны нүх ухах, мод тарих талбайд хар шороо буулгах ажлын хүрээнд 05 сарын 22-ноос 27-ний хооронд 10,000 модны нүх, 45 ховоо машин хар шороог бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэв. 6. Дүүргийн засаг даргын 2025 оны А/243 дугаар захирамжийн дагуу 21, 32 дугаар хороодын нутаг дэвсгэрээс үхсэн мал, амьтны сэг, зэмийг устгах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг 04 дүгээр сарын 26, 27, 29-ний өдрийн хооронд нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй, ховоо-3, ковш-1, экскаватор 1 ширхэг, трайлер-1, нийт 6 техниктэйгээр ажилласан. Бод 683 ширхэг, бог 1104 ширхэг, амьтан 94 ширхэг нийт 1767 ширхэг мал, амьтны сэг зэмийг цуглуулан ачиж 10 ховоо	
--	--	--	--	--	---	--

					машин сэг зэмийг тээвэрлэн ариутгал халдваргүйжүүлэлтийг бүрэн хийж ажилласан. 7. Дүүргийн засаг даргын 2025 оны А/232 дугаар захирамжийн хүрээнд 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн тарилтын ажлын хүрээнд Бумбатын рашааны дээд талын 1083 метр урт торон хашааг сэргээн засварлах ажлыг бүрэн хийж ажилласан. Бумбатын рашааны доод талын 2868 мерт урт хашаа татаж сэргээн засварлахаас 878 мерт урт хашааг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар сэргээн засварлаж шинээр татаад байна. 8. Дүүргийн засаг даргын 2025 оны А/246 дугаар захирамжийн дагуу 1, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 21, 23, 24, 25, 28, 30, 31, 39, 40, 42, 43 дугаар хороодын нийт 20 хороонд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 879,500 м2 гудамж зам талбайг автогрейдрээр түрж тэгшилж, 520 ховоо машин дайрга асгаж ковшоор түрж тэгшилж ажилласан байна. 9. Дүүргийн засаг даргын 2025 оны А/232 дугаар захирамжийн дагуу Цагдаа толгойн цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа нь доторх шар өвсийг цэвэрлэн зулгааж, сандал, хогийн сав, сүүдрэвчийг сэргээн засварлах, будах, хөл бөмбөгийн талбайн ногоон зүлгийг наах, шинээр 7 ширхэг камер	
--	--	--	--	--	--	--

					суурилуулсан, тойрсон хашаа нь нурсан байсныг төмрийг нь гагнаж, тоосго өрж битүүлсэн, гэрэлтүүлгүүдийг асаасан, усалгааны системийг ажиллагаанд оруулж, саравчны дээврийг зассан, 372 модны нүх ухаж 1200 метр 18 эгнээ шуудуу ухаж мод тарих, 4 ховоо машин хар шороо буулгах тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэв. 10. Дүүргийн засаг даргын 2025 оны А/233 дугаар захирамжийн дагуу нийт 13 хорооны 13 байршилд тоглоомын талбай засварлахаас 2,10,11,22,35,41,42 дугаар хороодын 7 байршилд тоглоомын талбайн шийд, самбарыг шинээр сольж, гэрэлтүүлэг, чийрэгжүүлэх төхөөрөмж, бетон шал цутгаж, хашаа болон сандлыг гагнаж, өнгийг сэргээн будаж засаж янзалсан. 11. Дүүргийн засаг даргын 2025 оны А/303 дугаар захирамжийн дагуу 29 хорооны үерийн далангийн дугуйн замын тохижилтын ажлыг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн тус байршилд урд, хойд талд 500м урт 3,100 ширхэг явган хашлаг хийж, 800м урттай асфальтан бетон хучлага хийж ажилласан ба хашаа, явган болон дугуйн замын тэмдэг, тэмдэглээлгээ, хөтөч зурвас татах, гэрэлтүүлэг	
--	--	--	--	--	--	--

						суурилуулах ажлууд хийгдэж байна. 12. Дүүргийн засаг даргын тамгын газар болон хороодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу 12, 14, 16, 26, 30 дугаар хороодын нутаг дэвсгэрт нийт 5 байршилд 7 метр өргөнтэй, 3 метр өндөртэй өндрийн хаалтыг хийж гүйцэтгэсэн. 13. Нийслэлийн засаг даргын А/237, Дүүргийн засаг даргын А/150 дугаар захирамжийн дагуу 18, 19, 29 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд явган замын 150 м2 зам талбайн эвдрэлийг засаж хэвийн болгож ажилласан. Нийт дараах 13 төрлийн тохижилт бүтээн байгуулалтын ажиллуудыг хийж гүйцэтгээд байна.	
3.1.2	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, дүүргийн Засаг даргын өмнө хариуцах	-	-	-	-	Захирлын 3 удаагийн А тушаалаар нийт 2,625,654,271 төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийг данс бүртгэлд бүргэн авч Нийслэлийн өмчийн харилцааны газарт баталгаажуулах хүсэлтийг хүргүүлээд байна. -Хөрөнгө бүртгэлийн тооллоготой холбоотой ЗДТГ-аас байгуулсан ажлын хэсэгтэй хамтран Хүүхдийн тоглоомын талбайн тооллогыг 1 удаа зохион байгуулаад байна.	100%

3.1.3	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх				1.2025 оны 1-3 сарын хугацаанд туршилтын хугацаагаар ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАТАЙ хамтран 2,3 дугаар хороонд байрлах Дахиврын цэгүүдийг манай байгууллагаас цэг тус бүрд 2 хүн цэгүүд хооронд түүхий эдийг цуглуулах портер машин 1 тус тус гарган хамтран ажилласан ба ТВ, сайтуудуудад уг үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулсан ба ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА цаашид уг үйл ажиллагааг явуулахаас татгалзсан болно. 2. Нийслэлийн засаг даргын 2024 оны А/1541 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2025 оны А/20 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж тус байгууллагаас 8 алба хаагч, 40 дүгээр хорооноос 11 алба хаагч, Гэрлэх ёслолын ордон 10 алба хаагч, Тээврийн цагдаагийн алба 8 алба хаагч нийт 37 хүний бүрэлдэхүүнтэйгээр дүүргийн 40 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 11 хэсэгт баг болон хуваагдан айл өрхөөр орж агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргаж мөн айл өрхийн зуух, яндангийн битүүмж, зориулалтын түлш түлж байгаа эсэх, утаа мэдрэгч зэрэгт хяналт	100%
-------	---	--	--	--	--	------

						тавьж нийт 2100 гаруй өрх айлаар орж судалгаа гаргах ажлыг гүйцэтгэн ажилласан байна. 3. Дүүргийн засаг даргын уриалгын дагуу зориулалтын ундны ус зөөвөрлөх, хадгалах савыг сольж, шинэчлэх ажлын хүрээнд 43 дугаар хорооны 60 өрхөд усны сав гардуулав.	
3.1.4	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг түргэн шуурхай өгч, шийдвэрлэлтийн хугацааг 2 дахин бууруулах					Тус байгууллага нь 2025 оны эхний 5 сарын байдлаар нийт 16 ширхэг өргөдөл хүлээж авснаас алба хаагчаас 7 өргөдөл ирснийг холбогдох арга хэмжээг авч ажилласан. Мөн иргэнээс ажилд орох хүсэлт 4 хүсэлт ирснийг хуулийн хугацаанд нь хянан хэлэлцэж шийдвэрлэсэн. Иргэнээс цаг үеийн асуудлаар холбогдсон 5 өргөдөл ирснийг холбогдох алба хаагч нарт шилжүүлэн холбогдох арга хэмжээг авч ажилласан.	100%
3.1.5	Монгол хэлний тухай хууль, холбогдох стандартыг байгууллагын хэмжээнд мөрдүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах					Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, зохион байгуулах MNS 5140:2021 стандартыг мөрдөн ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд архив, албан хэрэг хөтлөлтийн талаар гарсан бүхий л дүрэм зааврыг баримтлан ажиллаж, тайлан мэдээг хугацаанд нь чанартай гаргаж холбогдох хэлтэс	100%

						албадад хүргүүлж ажилласан байна. 2025 оны хагас жилд Ирсэн бичиг 171, Явсан бичиг 60 боловсруулан тоон гарын үсгээр илгээж албан бичгийн шийдвэрлэлт 100%, хугацаа хоцорсон болон зөрчил дутагдал байхгүй байна	
3.1.6	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд олон нийтийг танилцах боломжоор хангаж ажиллах	-	-	-	-	Олон нийтэд албаны талаар зөв мэдээлэл сурталчлан таниулах, Дүүргийн Засаг даргаас манай байгууллагад холбоотой гарсан Захирамжийн хэрэгжилт, хийгдсэн ажлын мэдээллийг албан ёсны Вэб сайт https://dedbvtets.shd.gov.mn/ болон Фейсбүүк нүүр хуудас Сонгинохайрхан дүүргийн Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ цахим хуудсаар дамжуулан 2025 оны 1 дүгээр улиралд 35 пост мэдээ оруулж нийт 5000 хүнд хүрч иргэд болон байгууллагуудад мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.	100%
3.1.7	Ажилтан, албан хаагчдыг тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах					Нийт алба хаагч нарт Эх үрсийн баярыг тохиолдуулан 4 ба түүнээс дээш хүүхэдтэй бол 200,000 төгрөг, 3 ба түүнээс доош хүүхэдтэй бол 100,000 төгрөгөөр тооцож нийт 2,900,000 төгрөгийг олгоод байна. Алба хаагч нарийг урлаг соёлын арга хэмжээнд хамруулах зорилгоор МУСТА Э.Марал-Эрдэнэ, МУСТА Бор	

						Мэндээ нарийн тоглолтыг үзүүлэх зорилгоор нийт 1,500,000 төгрөгийг тус тус олгоод байна. 2025 оны Сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан байгууллагын удирдлагаар батлуулж, төлөвлөгөөний дагуу дүүргийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсүүдтэй хамтран алба хаагч нарт 2 удаагийн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажиллаад байна.	
3.1.8	Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх					Захиралтай байгуулах төлөөлөн гүйцэтгүүлэх хариуцлагын гэрээний дагуу хүлээх үүргийн хэрэгжилтийг хангаж холбогдох тайлан мэдээг хүргүүлэн ажиллаад байна.	100%
3.1.9	Дүүргийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах					Оны хагас жилийн байдлаар Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд байгууллагын Захирал 8 удаа, ЗУХДарга 2 удаа орлон оролцсон байна. Шуурхай зөвлөгөөн дээр өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрд нь хариуцсан албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.	100%
3.1.10	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн					Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын тайлан мэдээг 100% гарган дүүргийн засаг даргын тамгын газарт хүргүүлээд байна.	100%

	холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах						
3.1.11	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах					Газрын санхүүгийн тайлан мэдээ болон санхүүгийн холбогдох мэдээ, тайлан, судалгааг ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс шаардсан хугацаанд хүргүүлж ажилласан. Санхүүгийн үйл ажиллагааны талаарх 24 төрлийн мэдээ, мэдээллийг тухайн сар, улирал, жилээр хуулийн хугацаанд гаргаж www.shilendans.gov.mn цахим системээр олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж, газрын шилэн дансны мэдээллийн самбарт байршуулж ажилласан байна. ЗГ-ын 43-р тогтоолын дагуу төсвийн хөрөнгийг үр дүнтэй, хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажиллаж байна. - Дараа жилийн төсвийн төсөл. - Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ. Төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт. - 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг. - Бонд, зээл, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр.	100%

						- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ. - Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт зэрэг мэдээллүүдийг цаг тухайд нь шилэн дансны сайтад оруулж, албаны шилэн дансны мэдээллийн самбарт байршуулсан.	
	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дүүргийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх					Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд урьдчилсан үзлэг шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээний хүрээнд өгсөн зөвлөмж үүрэг чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна.	100%

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

П.ПҮРЭВСҮРЭН